



**ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус газрын 2019 оны улсын төсвөөс санхүүжүүлэх шатахуун нийлүүлэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга

С.Ганзориг

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга;

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга

З.Гэрэлмаа

Гадаад харилцааны мэргэжилтэн;

Гишүүд:

Г.БАЗАРГҮР

Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн;

Б.Оюунцэцэн

Барааны тэмдгийн шинжээч;

Б.Анудар

Худалдан авах үйл ажиллагааны хөтөч ТББ-ын нягтлан бодогч;

2.Гүйцэтгэгчийг холбогдох хууль, журмын дагуу үнийн санал авах баримт бичгийг боловсруулж, сонгон шалгаруулж, дүгнэлт гарган танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭРДЭНЭСҮРЭН

000028